



МОНГОЛ УЛСЫН  
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН  
САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Нэгдсэн Үндэстний гудамж 5/2, Засгийн газрын II байр,  
Утас: 26 28 30, 26 61 71, Факс: (976-11) 32 09 43,  
И-мэйл: contact@mne.gov.mn, Вэбсайт: www.mne.mn

2021.10.01 № 01/4593  
танай 2021.09.13-ны № 33 -т

Хариу хүргүүлэх тухай

Танай ирүүлсэн 2021 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 33 дугаар албан бичигтэй танилцлаа.

“Алсын хараа-2050” /УИХ, 2020/ I үе шатны (2021-2030) зорилтын 6.1.4-т “Цэнгэг усны нөөц, урсац бүрэлдэх эх, ойн сан бүхий газар, биологийн олон янз байдлын хувьд чухал газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах судалгаа хийж өргөжүүлж замаар онцлог экосистемийн үйлчилгээ, үнэ цэнийг нэмэгдүүлнэ”, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван чиглэл” /УИХ, 2020/ 6.1.1-т “Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөн нийт газар нутгийн 27 хувьд хүргэж, цэнгэг усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийн 55 хувийг улсын тусгай хамгаалалтад авна”, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр” /УИХ, 2020/ 5.1.6-д “Цэнгэг усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийн 55 хувийг улсын тусгай хамгаалалтад авна” хэмээн тодорхойлсон төрийн бодлого, зорилтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

1975 онд Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 84 дүгээр зарлиг, 1995 оны УИХ-ын 26 дугаар тогтоолоор 927109.9 га талбай бүхий Говийн их дархан цаазат газрын Б хэсгийг улсын тусгай хамгаалалтад авсан.

Байгаль орчны сайдын 1990 оны 98 дугаар тушаалаар Говь-Алтай аймгийн Бугат сумын Биж багт “Тахь үржүүлэх хэсэг”, Байгаль орчны сайдын 1996 оны 02 дугаар тушаалаар “Тахь нутагшуулах эрдэм шинжилгээний туршилтын төв”, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2009 оны 75 дугаар тушаалаар Говийн их дархан цаазат газрын Б хэсгийн хамгаалалтын захиргааг байгуулж, Говийн их дархан цаазат газрын Б хэсэг /ГИДЦГ Б хэсэг/, Алаг хайрхан уулын байгалийн нөөц газар, Шаргын байгалийн нөөц газруудыг хариуцуулж, тусгай хамгаалалттай газрын хамгааллын менежмент, судалгаа шинжилгээ, сургалт сурталчилгаа, хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах чиг үүргийг хүлээлгэсэн.

“Зарим газрыг улсын тусгай хамгаалалтад авах тухай” Монгол Улсын Их Хурлын 2019 оны 41 дүгээр тогтоолоор Говийн их дархан цаазат газрын Б хэсгийн нутаг дэвсгэрт ирвэс, тахь зэрэг нэн ховор амьтан, аргаль, янгир, хулан, хар сүүлтий зээр зэрэг ховор амьтад тогтвортой байрших, шилжилт хөдөлгөөн хийх, ашигт малтмалыг үйл ажиллагаанаас хамгаалах зэрэг үндэслэлээр 911955.75 га талбайгаар өргөтгөж, нийт талбайн хэмжээ 1.835.724.94 га болсон.

Тус дархан цаазат газрын 65 хувь нь Ховд аймаг, 35 хувь нь Говь-Алтай аймагт тус тус харьяалагдаж байна.

Өнөөдрийн байдлаар тус дархан цаазат газарт 350 тоо толгой тахь сэргээн нутагшиж, 13000 орчим хар сүүлтий зээр, 9000 орчим хулан зэрэг ховор амьтад тогтвортой байршиж байна.

Үүнтэй холбогдуулан дархан цаазат газарт хамгааллыг оновчтой, түргэн шуурхай хэрэгжүүлэх нөхцөлийг хангах зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2021 оны А/45 дугаар тушаалаар зөвхөн Хамгаалалтын захиргааны нэрийг “Зүүнгарын говийн дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа” болгон өөрчилж, байршлыг Ховд аймгийн Алтай суманд шилжүүлэхээр шийдвэрлэсэн.

Монгол Улсын Их Хурлын гишүүн танаас ирүүлсэн асуулгын талаар:

1. ГИДЦГ-ын А, Б хэсгийн хамгаалалтын захиргааг олон нийт маш их андуурдаг ба мазаалай, хавтгай, тахь аль хэсэгт амьдардаг талаар байнга төөрөлдөх зэрэг асуудал гардаг тул Хамгаалалтыг захиргааны нэрийг холбогдох мэргэжлийн байгууллагын саналуудыг үндэслэн Зүүнгарын говийн дархан цаазат газар болгон өөрчилсөн. Анх эрдэмтэн судлаач О.Намнандорж гуай “Монгол орны физик газарзүй” номдоо өнөөгийн Говь-Алтай аймгийн Бугат сумын Хөвчийн нуруунаас баруун тийш Ховд аймгийн Булган сумын Байтаг Богд уулын ар хоолой хүртэлх говийг Зүүнгарын говь хэмээн нэрлэн бичсэн байдаг. ГИДЦГ-ын “Б” хэсгийн Хөвчийн нуруунаас баруун тийш орших нийт нутаг дэвсгэр нь физик газар зүйн мужлалтаар Говийн их мужийн Алтайн өвөр говийн мужийн Зүүнгарын говийн тойрогт ордог (Монгол улсын үндэсний атлас 2009).

2. Хамгаалалтын захиргаа нь дархан цаазат газрын зүүн хойд захад Бугат сумын Тахийн талд байрлаж баруун хэсэгтээ хүрч ажиллаж чадахгүй байгаатай холбоотойгоор хууль бус зөрчлүүд, дархан цаазат газрын баруун хэсэгт гарч, хяналт шалгалт, хяналтын постын ажлыг илүү өртөг зардалтайгаар хэрэгжүүлснээр байна. Жишээ нь: Ховд аймгийн Булган сумын Байтаг багийн нутагт орших алтны зөрчлийг таслан зогсоох Цагаан толгойн пост дээр 2021 оны 01 дүгээр сараас хойш ажиллахад Тахийн талаас нэг талдаа 260 км замыг туулдаг бол Алтай сумаас 130 км замыг туулж очих ба шатахууны зардлыг 50 хувь бууруулах боломжтой. Ховд аймгийн Алтай сум нь дархан цаазат газрын чанх голд нь байрладаг, дэд бүтэц бүрэн шийдэгдсэн сум тул төрийн захиргааны байгууллага хамгийн бага зардлаар ажиллах бүрэн боломжтой. Тахийн талаас санхүүгийн гүйлгээ хийх, хугацаатай албан бичиг шууданд хүргүүлэхээр Монгол Алтайн нурууг давж, өвлийн хугацаанд цас, мөсөнд хаагддаг замаар нэг талдаа 80 км, 2010 оны өвөл Элгэний застараар тойрч нэг талдаа 400 км замыг 72 цаг явж Бугат сум руу очдог байна. Төрийн сан, шуудан, банкны үйлчилгээг Бугат сумаас авахад өнгөрсөн хугацаанд илүү шатахуун зарцуулдаг байсан. Хамгаалалтын захиргааны дарга Төрийн сангийн үйлчилгээг Тахийн тал руу шилжүүлэх талаар Сангийн яаманд хандсан боловч шийдвэрлэх боломжгүй гэсэн хариу авсан. Хамгаалалтын захиргааны дарга, нягтлан хоорондоо 80 км зайтай ажилладаг төрийн захиргааны байгууллага, төсвийн захирагч өөр хаана ч байхгүй байсан тул бид энэ шийдвэрийг гаргахад хүрсэн юм.

3. ГИДЦГ-ын “Б” хэсгийн газар нутгийн 40% Ховд аймгийн Алтай сум, 25% Говь-Алтай аймгийн Бугат суманд хамаардаг тул Алтай сумаас хяналт шалгалтын ажлыг шуурхай хүргэх боломжтойгоос гадна өнгөрсөн хугацаанд хийгдсэн судалгаа шинжилгээний ажлаар хулан, хар сүүлтий зээр хамгийн эрсдэлтэй өвлийн хугацаанд Ховдын нутагт өвөлждөг нь тогтоогдсон тул тухайн амьтдын хамгаалалтыг эрс сайжруулах бүрэн боломж нээгдэнэ. Ховдын Алтай сум нь 12 жилийн сургуультай тул албан хаагчдын хүүхдүүд нэг сургууль, ангидаа суралцах боломжтой. Өнөөдөр албан хаагчдын хүүхдүүд Тахийн талын бага сургуульд 1-5 дугаар анги, Бугат сумын дунд сургуульд 6-9 дүгээр анги, Төгрөг, Есөнбулаг сумдын сургуульд 10-12 дугаар ангидаа суралцаж 3 шатны сургууль дамжиж байна.

4. Олон улсын тахь групп төрийн бус байгууллага 1999 онд байгуулагдаж Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай 2001-2011, 2011-2021 хүртэлх хамтын ажиллагааны гэрээ байгуулж, Тахийн талд 225 м<sup>2</sup> талбайтай, нэг давхар тоосгон барилга 2005 онд ашиглалтад оруулж, 2019 онд цэвэр усны шугамд холбож, 10 кваттын нарны эрчим хүчний станц суурилуулсан. Тахь сэргээн нутагшуулах үйл ажиллагаа, судалгаа шинжилгээний ажил, Хамгаалалтын захиргааны албан хаагчдыг чадавхжуулах, техник тоног төхөөрөмжөөр хангах ажилд 2011-2020 онд 778370.05 ам долларын хөрөнгө оруулалт хийсэн.


5. Ховд аймгийн Алтай суманд Хамгаалалтын захиргааг шилжүүлснээс хойш одоогийн орон тоон дээр нэг мэргэжилтэн, 2 үйлчилгээний ажилтан нэмж ажиллуулах төлөвлөгөөтэй байгаа ба Тахийн талд Говь-Алтай аймгийг хариуцсан хамгаалалтын хэсэг, тахь нутагшуулах, судалгаа шинжилгээний төв байгуулж 2 мэргэжилтэн, 10 байгаль хамгаалагч, 2 үйлчилгээний ажилтан тогтмол ажиллуулна. Говь-Алтай аймгийн Бугат сум дахь 8 байгаль хамгаалагчдыг тогтвортой ажиллуулахын тулд Засгийн газрын “Байгалийн бүсчлэлд хамрагдах сумдын нэрийн жагсаалт батлах тухай” 2006 оны 71 дүгээр тогтоолд Бугат сумыг цөлийн бүсэд хамруулсныг өндөр уулын бүс рүү шилжүүлэх шийдвэрийг гаргуулахгүй бол Бугат сумаас ГИДЦГ-ын “Б” хэсэгт 458,4 мянган га талбай хамрагддаг тул 3 байгаль хамгаалагч ажиллах нормативтай байдаг.

6. Хамгаалалтын захиргаа Ховд аймгийн Алтай суманд 15 жилийн хугацаатай 1 га газар эзэмших гэрээ байгуулсан ба тухай газарт мэдээлэл, сургалт сурталчилгаа, хамгаалалтын захиргааны үйл ажиллагаа явуулах зорилготой нийт 825 м<sup>2</sup> талбайтай барилгын зураг төслийг боловсруулах ажлыг Олон улсын тахь групп нийгэмлэгийн санхүүжилтээр хийж гүйцэтгэн ХБНГУ-ын “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нь төсөл”-ийн дэмжлэгтэйгээр 2022 онд барьж байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

7. Дархан цаазат газрын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хэмжээ, хилийн цэс, сумдын эзлэх талбайн хувь, Ховд аймгийн Алтай суманд баригдахаар төлөвлөж буй барилгын ерөнхий төлөвлөгөөг тус тус хавсаргав.

Аймаг, сумын нэр	Талбайн хэмжээ /мян.га/	Эзлэх хувь
Ховд аймаг, Алтай сум	745,1	40%
Говь-Алтай аймаг, Бугат сум	458,4	25%
Ховд аймаг, Үенч сум	308,8	16.8%
Говь-Алтай аймаг, Тонхил сум	170,1	9.2%
Ховд аймаг, Булган сум	153,3	9%

Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа нь зөвхөн нэг аймгийн нэг суманд үйл ажиллагаа хэрэгжүүлдэггүй тул хууль тогтоомжийг хэрэгжүүлэхээр гаргаж буй бидний шийдвэрийг гишүүн та дэмжин ажиллана гэдэгт гүнээ найдаж байна.

 Н.УРТНАСАН



**БАЙГАЛЬ ОРЧИН,  
АЯЛАЛ ЖУУЛЧУЛАЛДЫН ЯАМ**

**"БЬЮДИНГС ТЕХНОЛОЖИ" ХХК**

/ЭТ16-116/21, Улаанбаатар хом, БСД, 9-р хороо, Алмэйн 8-р гудамж,  
"Хэйнор" Оффисын барилга 13-р дахьар, Улс: 350014, Факс: 350013/



**ENGINEERING COMPANY**



Ховд аймгийн ерөнхий архитектор ..... /З.Өмүртай/

"ХОВД АЙМАГ, АЛТАЙ СУМ" ХХК

**"Зүүнгарын говийн ДЦГ-ын хамгаалалтын захиргааны оффис  
ба мэдээлэл сургалтын төв"-ийн барилга"**

(Эзгвэр зураг)

БАРИЛГА АРХИТЕКТУРЫН ХЭСЭГ-БА

**БАТЛАВ:**

Амбан мұшарал	Нэр	Гарын үсэг
БОАЖЯ-ны Тусгай хамгаалалттай бүс нүмгийн удирдлагын газрын дарга	Д. Балмөнх	

**ТАНИЛЦСАН:**

Амбан мұшарал	Нэр	Гарын үсэг
БОАЖЯ-ны Тусгай хамгаалалттай бүс нүмгийн удирдлагын газрын мэргэжилтэн	Т. Болдбаатар	
БОАЖЯ-ны Тусгай хамгаалалттай бүс нүмгийн удирдлагын газрын мэргэжилтэн	Б. Энхээрэл	

**ХЯНАСАН:**

Амбан мұшарал	Нэр	Гарын үсэг
"Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлдөө дасан зохицох" (БОРБХУАӨДЗ) төслийн Зөвлөх багийн Кадетер, ТХН-ийн менежерийн зохицуулагч	Г. Гансүх	
Олон улсын шахь групп нийгэмлэгийн Монгол дахь мөвлөөгчийн газрын Гүцэтгэх захирал	Ж. Балтүх	
Зүүнгарын говийн ДЦГ-ын хамгаалалтын захиргааны дарга	О. Ганьдаатар	



**БОЛОВСРЧУЛСАН:**

Гүцэтгэгч:	Нэр	Гарын үсэг
	БЬЮДИНГС ТЕХНОЛОЖИ " ХХК-ийн гүцэтгэгч захирал	Б.Түвшэндэл

Улаанбаатар хом

2021 он

1	2	3	4	5	6	7	8			
Хөдөө ажлагийн ерөнхий захирал З.Өмнөд Д.Батмөнх			Үндэслэл: - Хөдөө ажлагийн Амны сурны зогсон дараан 2021 оны 04-дугаар сарын 23-ны өдрийн А/161 тоон газар эзэмшүүлэх захиралж, 2021 оны 06-р сарын 11-ны өдрийн 12/2021 дугаар захиралжир мөнгөлөлтийн даалгавар, 2021 оны 07-р сарын 08-ны өдрийн 07/2021-р зурга төсөл боловсруулах даалгаврыг үндэслэн - "ИНЖЕНЕР ГЕОДЕЗИ-ХХК-д 07/2021 оны боловсруулсан төслийг дагуу эгц зурга дээр үндэслэвэн хийгээв - Хол мэдээлэл төлөвлөлт, барилдажлын норм ба дүрэм БНД 30.01.04 үндэслэн ерөнхий төлөвлөвөний зургийг зүүцлээв.			ТӨДӨРХӨЙЛӨНТ 1. Даргач 2. Ямар ч 3. Ямар чгүй эн 4. Нэгэн бодууламж 5. Алдс 6. Гэрж			ТЭМЦ Төлөвлөж буй барилга Төлөвлөж буй барилга Төлөвлөж буй барилга Төлөвлөж буй барилга Төлөвлөж буй барилга Төлөвлөж буй барилга	




- ТӨРӨЛӨГӨН ТЭМЦ
- Төлөвлөж буй барилга
  - Пандус
  - Ногоон сүүлгэмэл
  - Авто зогсоол
  - Төлөвлөж байгаа хашаа, хягтар
  - Бомж усны шугам
  - Дулааны шугам
  - Цэвэр усны шугам
  - Цахилгааны шугам

ТАЙЛБАР:

Үндэслэл:  
 - 2019 оны боловсруулсан дэвсгэр зурга.  
 - Хол мэдээлэл төлөвлөлт, барилдажлын норм ба дүрэм БНД 30.01.04 үндэслэн ерөнхий төлөвлөвөний зургийг зүүцлээв.

F	1	2	3	4	5	6	7	8	A3	
"ЭҮГЧЛЭЛЭЙН ТӨВИЙН ДҮГЭЙН ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААНЫ СӨЖ БА ХАЛДЛАЛ СЭЛЭЛЭЙН ТӨВ"-ийн болон "Гучимээгч" БЭЛЭЛЭЙН ТЕХНОЛОГИ "ХХК-ийн зүүцлээв захиралжир		Хөдөө ажлагийн Амны сурны зогсон "ЭҮГЧЛЭЛЭЙН ТӨВИЙН ДҮГЭЙН ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААНЫ СӨЖ БА ХАЛДЛАЛ СЭЛЭЛЭЙН ТӨВ"-ийн болон "Гучимээгч" БЭЛЭЛЭЙН ТЕХНОЛОГИ "ХХК-ийн зүүцлээв захиралжир		Гучимээгч, АРХИТЕКТОР Эхлэлдэгч: Бадмаагийн Түвшин барилдажлын норм ба дүрэм БНД 30.01.04 үндэслэн ерөнхий төлөвлөвөний зургийг зүүцлээв		НЭР Б.Түвшин Б.Түвшин Б.Түвшин Б.Түвшин Б.Түвшин Б.Түвшин Б.Түвшин Б.Түвшин		ГАРЫН ҮЙС Б.Түвшин Б.Түвшин Б.Түвшин Б.Түвшин Б.Түвшин Б.Түвшин Б.Түвшин Б.Түвшин		ЗАЙВАР ЗУРАГ М1:500 1 үеэс 6 2021 он 7 сар

ХАРАГДАХ БАЙДАЛ



<p>Хаяг Шинэ Архитект Групп</p> <p>"ЭУУГ АЖАЙ ГОВИЙН ДЛГ-ЫН ХАМГААЛЛАЙН ЗАХИГАЛНЫ ОФИС БА МЭДЭЭЛЭЛ СЭРГЭЛЭЙН ТӨВ"-ийн борлуу Гүйцэтгэгч: "БЫВЛИДИГС ТЕХНОЛОЖИ" ХХК-ийн гүйцэтгэгч захиула</p>		НЭР	ГАРЬНГЭСЭГ	ЗАГВАР ЗҮРЭГ
Гүйцэтгэгч:	АРХИТЕКТОР	Б.Түнэнцол		М1:100
Захиулагч:	БДХХЯ-ийн Тусгай хөнгөлөлтийн бүс нийслэл үйеэдийн ажлын ордон	Д. Болонж		Хуудас 11
				2021 он 7 сар

